

## Олборлох салбарын авлигын эрсдэлийг тодорхойлох төслийн дэд ажлын хэсгийн уулзалтын тэмдэглэл

2021 оны Зургаадугаар сарын 28, Даваа гараг, 15:00-16:50 цаг

### Zoom уулзалт:

Meeting ID: 980 5168 5075

Passcode: 125669

### Оролцогчид:

1. Ш.Цолмон, ОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч
2. Б.Ганхуяг, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар
3. А.Пүрэв, Уул уурхай, үйлдвэрийн яам,
4. Б.Эрдэнэцэцэг, Нүүрс ассоциацийн
5. Д.Цэрэнжав, Ил тод байдал сан ТББ-ын тэргүүн,
6. Д.Сүхбаатар, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын удирдах зөвлөлийн
7. С.Боргил, Судлаач
8. Д.Тэгшбаяр, Судлаач
9. Э.Мөнхжаргал, Судлаач
10. Н.Дорждарь, ББЗХ
11. Н.Золжаргал, ББЗХ
12. О.Солонго, ББЗХ

### Хураангуй

1. **Н.Дорждарь уулзалтыг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулав**
2. **“Олборлох салбарын авлигын эрсдэлийг тодорхойлох” судалгааны танилцуулга:**

Д.Тэгшбаяр, С.Боргил нар судалгааны явц, үр дүнг танилцуулав.

Уул уурхайн салбарыг сонгосон шалтгаан:

- эдийн засгийн өнөөгийн буюу ирээдүйн ач холбогдол;
- бусад салбарт үзүүлэх нөлөө;
- нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөө;
- авлига хамгийн их тархсан гэх олон нийтийн ойлголт бүрэлдсэн байдал

Тайланг дараах байдлаар долоон хэсэгт хуваав:

1. Олборлох шийдвэр, лиценз олгох ба гэрээ байгуулах явдал
2. Үйл ажиллагаа
3. Орлого хураалт
4. Орлогын хуваарилалт
5. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд

6. Эрчим хүчний шилжилт

7. Улс төрд нөлөө бүхий этгээдийн ёс зүйгүй байдал

Эдгээр долоон хэсгийг дараах асуудлуудаар авч үзсэн болно:

- авлигын тодорхой эрсдэлийн ач холбогдол, цаг үеэ олсон байдал,
- авлига хор уршиг дагуулж болзошгүй чиглэлүүд,
- өөрчлөлт хийх боломж байгаа чиглэлүүд.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Шийдвэрийн гинжин хэлхээ ба засаглалын асуудлууд	Энэ чиглэлд анхаарал хандуулах нь чухал уу?	Энэ чиглэлд анхаарал хандуулах нь цагаа олсон уу?	Энэ чиглэл дэх авлига ноцтой, хор уршигтай байна уу?	Эерэг өөрчлөлт хийх боломж бий юу?
1.Олборлох шийдвэр, лиценз олгох ба гэрээ байгуулах явдал	чухал	тулгамдсан	тийм	тийм
2.Үйл ажиллагаа	чухал	тулгамдсан	тийм	зарим
3.Орлого төвлөрүүлэлт	чухал	тулгамдаагүй	зарим	зарим
4.Орлогын хуваарилалт	тодорхой хэмжээнд чухал	тулгамдсан	зарим	зарим
5.Төрийн өмчит аж ахуйн нэгжүүд	чухал	тулгамдсан	тийм	зарим
6.Эрчим хүчний шилжилт	тодорхой хэмжээнд чухал	тулгамдаагүй	зарим	Үгүй
7.Улс төр, эдийн засгийн дээд хүрээллийн дунд үүсэх зүй бус ойр харилцаа	чухал	тулгамдаагүй	тийм	зарим

**3. Нарийвчилсан судалгаа хийх чиглэл сонгох:**

Нэгдсэн дүгнэлтээс **чухал, тулгамдсан, тийм** хариултауд хамгийн ихээр авсан гурван чиглэлээс аль нэгийг сонгохыг дэд ажлын хэсгийн гишүүд хэлэлцэн шийдвэрлэв.

**Б.Ганхуяг:** Судлаачдадаа баярлалаа. Илтгэл дээр тоон мэдээлэл ерөөсөө дурдсангүй, гэхдээ тайланд орсон байх, тайлантай хараахан танилцаж амжаагүй байна. Авлигатай тэмцэх газраас гарч байгаа бодит байдал дээрх авлигын тоо баримтыг надаас авч болно шүү, миний зүгээс мэдээллээр хангахад бэлэн байгаа. Нарийвчилсан үнэлгээг үйл ажиллагаа гэсэн чиглэлд хийвэл яасан юм бэ гэсэн саналтай байна.

**Э.Мөнхжаргал:** Эхний ээлжинд бид ерөнхий байдлаар танилцуулаад, дараа нь чухал гурван сэдвээ сонгоод нарийвчилсан судалгаа эхлэх байгаа, тэгэхдээ илүү тоон баримт мэдээллээ оруулаад явах байгаа шүү.

**А.Пүрэв:** Миний хувьд үйл ажиллагааг дэмжиж байна. Асуудал үүсдэг гэвэл миний бодож байгаагаар ажил гүйцэтгэх болон туслан гүйцэтгэгч сонгох, төрийн захиргааны байгууллагын нөлөөлөл мөн хүний нөөцийн асуудал зэрэг байна. Аймгийн хувьд Дорнодыг санал болгосоор байна.

**Ш.Цолмон:** Миний хувьд үйл ажиллагаа гэсэн ерөнхий чиглэлийг бол дэмжиж байна. Энэ дотроо саналаа хэлэхэд ханган нийлүүлэлт, худалдан авалт, ажил гүйцэтгэх болон туслан гүйцэтгэгч сонгох, хандив тусламж гэсэн чиглэл. Эдгээр дээр илүү авлигын эрсдэл үүсдэг.

**Б.Эрдэнэцэцэг:** Манайх үйл ажиллагаан дээр төвлөрөх саналтай байна. Үүн дотор төрийн захиргааны байгууллагын нөлөөлөл, ханган нийлүүлэлт, хандив тусламж байж болох юм.

**Д.Цэрэнжав:** Үйл ажиллагааг дэмжиж байна. Тэр дундаа ханган нийлүүлэлт, худалдан авалт, ажил гүйцэтгэх болон туслан гүйцэтгэгч сонгох, хандив тусламж гэсэн чиглэлүүдийг сонгож байна. Хандив тусламжийг заавал оруулах ёстой байх авлигатай холбогддог гэдэг утгаар.

Гишүүд хэлэлцэн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ хүрээнд нарийвчилсан судалгаа хийхийг дэмжив. Үйл ажиллагаа дотор дараах чиглэлүүд дээр төвлөрнө:

- ханган нийлүүлэлт, худалдан авалт
- хандив тусламж
- тээвэрлэлт, боловсруулалт, борлуулалт
- ажил гүйцэтгэх болон туслан гүйцэтгэгч сонгох

Хурлын шийдвэрийг том ажлын хэсэгт 6 сарын 30-ны өдрийн хурлаар танилцуулж эцэслэн судалгааны ажил эхлэх болно.